

**“МНТ”-ны нэгэн шүлгийг шинээр тайлбарласан эх
бичгийн харьцуулсан судалгаа**

Ш. Чоймаа (МУИС)

“МНТ”-нд өгүүлснээр, Тэмүжин бээр Ван хан, Жамуха хоёртой холбоо тогтоож, тэдний тус дэмээр гурван Мэргидийг мохоон дарж, гэргий Бөртэ Үжинээ авран авчирсны дараа, жил хагасын хир Тэмүжин Жамуха хоёр хамт нутаглаж байгаад салж нүүдэг. Тэдний салах болсон нь “МНТ”-нд дурдсан мэт Жамухын битүү өгт үгнээс эхтэй ч, үнэндээ бол Тэмүжин, Жамуха хоёрын ааш зан, алсын бодол эрс өөр тул хойшид нэгэн санаатан болж, хамт байх боломжгүйг хэн хэн нь ойлгосон хэрэг юм.

Тэмүжин Жамухаас салж нүүснээс хойш Хамаг монголчуудын өдий төдий нэр төртэй, нөлөө бүхий хүмүүс Тэмүжинийг дагахаар ирсэн билээ. Тэдний дотор Зэлмийн дүү Чаурхан, Сүбээдэй баатар нар ирсэн ажээ. Энэ үед Алтан Хучар, Сача бэхи тэргүүтэн зөтэлдэн зөвлөж, Тэмүжинд анх удаа Чингис хаан цол өргөж (1189 онд), Тэмүжин ч хаан болсон даруй, дагаж ирэгсэд, ойр шадар хүмүүстээ алба ажлыг хуваарилан өгөх үед, Жарчигудай Урианхай овогт Сүбээдэй баатар (1176-1248) Зэлмэ ах шигээ Тэмүжинд үнэнч зүтгэхээ батлан хэлсэн үг “МНТ”-ны 124 дүгээр зүйлд байдаг. Тэрхүү шүлэглэн хэлсэн үгийг “МНТ” болон Лу. “Алтан товч”-д хэрхэн бичсэнийг харьцуулан үзье:

§ 124 МНТ <<sübe’etei – ba’adur ügüлерүн quluqana bolju
ЛАТ 336 <<sübegedei (34a) bayatur ügüлерүн quluqan-a bolju
quriya[!]dusu qara kerі’e bolju qada’un bügün-i qarmaldusu nembe’e
quriyaldusu : qara keriy-e bolju yaduyun бүкүн-i qurimaldasu : nemüry-e
isgei bolju nemüreldün sorisu gerisge
šejegei (sajayai) metü nemüreleldün qoyisuyai [qorisuyai]¹ kerisge (keriy-e)

¹ Эртний уйгуржин монгол бичигт тохиолдох “г” гийгүүлэгчийн үсгийн махбод нь одоогийнх шиг том эрвээлжгүй байдаг тул хулсан үзгийн бичвэрт “i” үсэгтэй адил харагдах бүрэн боломжтой. Мөн үгийн дунд орсон “y, i, w” үсгүүд нь цөм нэгэн шилбээр тэмдэглэгдэх тул “г” үсгийн эрвээлж нь тодгүй буюу балархай бол шилбээр бичихээс өөр аргагүй.

isgei bolju ger жүк gerisgelelden sorisu ke'eba>>²
šejegei (saĵayai) bolju : ger жүг kerisleldün (gerlen) quriyasu kemebe>>³.

Тухайлан харьцуулж үзсэн хоёр сурвалжийн энэ хэсгийг судлаачид янз бүрээр хөрвүүлж, орчуулж, зарим үгсэд өөр өөрийн тайлбар хийж иржээ. "МНТ"-ны тухайд бол хятад хажуугийн орчуулгад түшиглэсэн байдаг. Тэр бүгдийг энд өгүүлэхгүй.

Лу. "Алтан товч"-ийг орчин цагийн монгол хэлэнд хөрвүүлж, кирилл үсгээр 1957, 1990, 1998 онуудад 3 удаа Улаанбаатарт хэвлэн гаргажээ. Дээр харьцуулсан шүлгийг 1990, 1998 оны кирилл үсгийн хэвлэлд хөрвүүлэхдээ:

"Сүбээдэй баатар өгүүлсэн нь:
Хулгана болж хураалдсу.
Хар хэрээ болж
Хатуу бүхнийг хурималдсу.
Амраг шаазгай мэт
Амраглан хураасугай.
Хэрээ шаазгай болж
Гэр зүг
Гэрслэлдэн хураасу хэмээв"

гэж буулгасан нь жинхэнэ эхийн үг утгыг ихэд ташаа болгожээ. Энэ нь аливаа сурвалж бичгийг монгол хэлэнд буулгахдаа бусад сурвалжтай харьцуулж, жинхэнэ эх бичгийн судалгаа хийх ёстойн нэгэн жишээ болжээ.

Бид, "МНТ" болон Лу. "Алтан товч"-ийн жинхэнэ эхийг харьцуулан үзэж, дундад үеийн монгол хэлний бусад сурвалж, алтай хэлний баримт зэрэгт тулгуурлан, "МНТ"-ны уйгуржин монгол эхэд доорхи мэт байсан болов уу гэж үзэж байна.

<< sübegedei bayatur ügülerün quluyana bolju quriyaldusu : qara keriy-e bolju yadayun (~yadayun) бүкүн-i qarmaldusu : nemürge sisegei bolju nemürleldün qorisu : kerisge sisegei bolju ger жүг kerisgeleldün qorisu kemebe >> [Сүбээдэй баатар өгүүлрүүн: Хулгана болж хураалдсу. Хар хэрээ болж, гадуун (гадуур) бүхнийг хармалдсу.⁴ Нөмрөг эсгий болж нөмрөлдөн хорису (хамгаалъя). Хэрсэг⁵ эсгий болж гэр жүг (гэр барааг, гэр ачааг) хэрсэглэлдэн⁶ хорису (хамгаалъя) хэмээв.]

Сэргээн тодотгож уншсан байдлаа нотлохын тулд цөөнгүй үгийн тухайд өмнөх судлаачдын судалгаа, орчуулга, сонгодог бичгийн өмнөх үеийн бичлэгийн онцлог зэрэгт дулдуйдан, зарим гол зүйлийг товч тайлбарлая.

² "Index to the Secret history of the Mongols" by Igor de Rachewiltz, Indiana University, Bloomington, 1972, pp. 52-53.

³ "Алтан товч" УБ. 1990 он (Гар бичмэл эхээс зургаар бэлдсэн хэвлэл), 336. 34а тал.

⁴ "Хорин нэгт тайлбар толь" (1717)-д "харлах" гэдгийг "Нэг газарт дүүргэх, хураах" гэж тайлбарлажээ.

⁵ Мөн тольд "Орд харшийн индрийн дээр хөндлөн тавьсан чулуу, мөн тагт асрын дээд, доод давхар саравчны доор хөндлөн модоор үйлдсэн"-ийг "keresge" (хэрсэг) хэмээнэ гэжээ.

⁶ Мөн тольд "Гацаалан хөндлөн халхлах"-ыг "keresgeleki" (хэрсэглэх) хэмээнэ гэжээ.

1. "МНТ"-ныг хятадаар галиглан орчуулагч болон гүүш Лувсанданзан нарын аль алинд нь ихэд элэгдэж хуучирсан, эртний уйгуржин монгол бичгийн хэв зурлагатай судар эх байсан тул эндүүрч уншсан зүйл хэн хэнд нь байжээ. Тухайлбал, эртний уйгуржин монгол бичгийн үгийн эхний "s", "q" хоёр үсэг хулсан үзгийн бичлэгт адилхан хэвтэй тул "МНТ"-ны галигч бээр "qorisu" гэдэг үгийг "sorisu" гэж ташаа уншаад, буруу орчуулжээ. Ийм эндүүрэл "МНТ"-ны хятад галигт цөөнгүй тохиолдож байгаа бөгөөд, тухайлбал, "МНТ"-ны 172-р зүйлд <<so'or äölö-tür>>, 162-р зүйлд <<tere so'or-tur>>, 177-р зүйлд <<tere so'or-tur>>, 208-р зүйлд <<naiman-i busangqui so'or-tur>> гэж байдаг. Энэ нь зөвхөн <<qorug>> (хоор, хооронд) гэдэг үгийн <<q>> үсгийг <<s>> үсгээр ташаа уншсанаас үүдсэн галиг билээ. Энэ хоёр үсгийн эндүүрлийн тухай өөр өгүүлэл бичиж байгаа тул түр орхиё.

2. "МНТ"-ны хятад галигт <<sorisu>> гэж ташаа уншсаныг Лувсанданзан гүүш бээр үгийн эхний <<s>> үсгийг <<q>>-гаар зөв уншжээ. Харин бүхэл үгийг яг <<qorisu>> буюу <<qorisuyai>> гэж уншиж бичээгүй нь тухайн эх бичгийн үсгийн тиг зурлага бүдэг балархай байсантай холбоотой буй за. Лувсанданзан гүүш уг шүлгийг бүрэн гүйцэд ухан ойлгоход, XVII зууны үе гэхэд нэгэнт хэлж ярихаа больчихсон, өөрөөр хэлбэл үгийн эхний <<s>> гийгүүлэгч аль хэдий нь сугарч гээгдсэн <<šejegi>> гэдэг сонин содон үг гарч, багагүй төөрөгдүүлжээ. Энэ нь эртний болоод дунд үеийн монгол хэлэнд <<sisgei>>, <<sisegei>> гэж хэлж ярьж байсан "эсгий" гэсэн үг билээ. Уг үгийг тэр үеийнхэн огт ойлгоогүйн шинж нь хажууд нь <<saǰayai>> шувууны нэр хадсан байдал тод гэрчилнэ.

Энд бас нэгэн асуулт гарч ирнэ. Хэрэв дунд үеийн монгол хэлэнд <<sisegei>> гэж хэлж ярьж байсан юм бол яг энэ шүлгийн мөр зэрэгцүүлсэн хятад галигт яагаад <<isgei>> гэж бичсэн байна вэ?. Үүний учрыг "МНТ"-ны хэл өөрөө хариулж байна. Бид "МНТ"-ноос хоёр эш татъя.

"МНТ"-ны 202-р зүйлд <<sisgei tu'urqatu>> (эсгий туургат) гэж галигласан атлаа дараах 203-р зүйлд <<isgei tu'urqatan>> (эсгий туургатан) гэж галигласан байдаг. Энэ нь 14-р зууны эцэс гэхэд аман аялгуунд уг үгийг эхний <<s>> гийгүүлэгч сулран сугарч эхэлснийг нуталж байна. Харин Лувсанданзанд байсан эхэд уг үгийг <<šejegi>> гэж эртний хэв хэлбэрээр нь бичсэн байжээ.

3. Орчин цагийн монгол хэлний эгшгээр эхэлсэн олон үгийн эхний гийгүүлэгч суларч сугарсныг судлаачид олж тэмдэглэсээр байгаа билээ. Энэ үгийн тухайд мөн адил юм. Орчин цагийн монгол хэлний <<isgei>> (эсгий) гэдэг үгийг дунд үеийн монгол хэлэнд <<sisegei>> гэж хэлж бичиж байсан баримт "МНТ"-ноос гадна "Мукаддимат-Ал-Адаб" толинд <<sisegei>>(sisegei-войлок; sisegei da'urγa –войлочное одеяние; siisegeiçi - кошемник; sisügei čadur-войлочный шатар)⁷, "Монгол-хуа-й-й-юй" толинд <<sisige>> гэж тохиолдож байх бөгөөд монгол хэлний эртний хэв

⁷ М. Н. Поппе "Монгольский словарь Мукаддимат Ал-Адаб", часть II, М-Л 1938, 323 стр.

байдлыг хадгалсан Могол, Дагуур зэрэг хэл аялгууны баримтууд баттай гэрчилж байна.

4. XVII зууны түүхч Лувсанданзан болон түүний бичээч нарт <<*sisegei*>> гэсэн бичлэгтэй үг огт ухагдсангүй тул тэдэнд байсан "МНТ"-ны эх судрын дагуу <<*kerisge, šejēgei*>> гэж хуулаад, хожим хажууд нь <<*keriy-e saǰai*>> (хэрээ, шаазгай) гэж ташаа тайлбар хаджээ. Энэ нь өнөө үед "Лу. Алтан товч"-ийг кирилл монгол бичгээр буулгаж хөрвүүлэгчид ихэд ташаарахын үндэс болжээ. Лувсанданзан бээр "эсгий" гэдэг гол үгийг сайн ухаж ойлгоогүйн улмаас бусад зарим үгийн бичлэгийг засаж хуулсан бололтой. Эртний уйгуржин монгол бичгийн дурсгалд үгийн дунд тохиолдох "s, j, č" гийгүүлэгчийн бичлэгийн хэлбэр тун адил байдгийг энд санах ёстой.

5. Бидний тухайлан ярьж байгаа энэ шүлэгт гарах "*nemürge*" (нөмрөг) гэдэг үгийг хятад галигт "*nembe'e*" гэж галиглаж, гүүш Лувсанданзан "*nemüry-e*" гэж бичсэн нь зөвхөн эртний уйгуржин монгол бичгийн бичлэгийн онцлог, үсэгзүйн учир шалтгаанаар тодорхой тайлагдах бөгөөд энэ үгийн талаар Хятадын Өвөр Монголын Их сургуулийн профессор Бүрэнбат их үнэмшилтэй тайлбарлаж бичсэн буй.

6. "МНТ"-ноос бидний эшлэн судалж байгаа богино шүлэгт <<*qorisu*>> гэдгийг <<*sorisu*>> гэж бичсэн нь үсэг бичгийн эндүүрэл болох нь тодорхой байхын хамт утгын хувьд "*corix*" гэдэг үг нийцэхгүй байгаа юм. Сүбээдэй баатарын үгэнд эзэн хааны эд хөрөнгийг хадгалж, хэрсэг эсгий мэт, нөмрөг эсгий мэт хаалт хамгаалалт болон халдах дайсныг хориглон хамгаалъя гэсэн утга байгаа билээ. Энд нэгэн зүйлийг тодотгон өгүүлэхэд, эртний болоод дунд үеийн монгол хэлэнд <<*qoriqu*>> гэдэг үгийн гол утга нь "хамгаалах" байжээ. Үүнийг Алтайн хэлний баримт, тухайлбал, эртний түрэг хэл нуталж байна.

Эртний түрэг хэлэнд, Махмуд Кашгарын толинд <<*qorī-oberegatъ, охранятъ; otīyqorīdī – он охранял пастбище*>>⁸ гэсэн утгатай ажээ.

Финляндын эрдэмтэн Martti Räsänen "...түрэг төрлийн олон хэлэнд << qorī- ~ когу>> гэдэг үйл үг нь харж хамгаалах, манах, тойрон хамгаалах гэсэн утгатай бөгөөд монгол хэлний "qorī –" үгтэй гарлын холбоотойг тэмдэглэжээ.⁹

Дээр өгүүлснээс дүгнэн өгүүлэхэд, Сүбээдэй баатар хаан эзэн чиний эд барааг нөмрөг эсгий мэт, хэрсэг хашаа мэт тойрон хүрээлэн манаж хамгаалж байа хэмээсэн нь тодорхой юм.

7. "МНТ"-ны хятад галиг эхэд "*ger jüg*" гэдгийг хятад орчуулгандаа "гэр орон, гэр сууц" гэсэн утгатай хоршоо үгээр хадаж орчуулаад, ерөнхий орчуулгадаа орхисон ажээ. Судлаачид ихэнх нь "зүг" гэсэн монгол үгээр ухаарсан байдаг боловч хам сэдэвдээ утга нь нийлдэггүй юм. Бид эрт, эдүгээгийн түрэг төрлийн хэлнүүдэд "yük", "yok", "jük", "čük"

⁸ Древне-тюркский словарь, Ленинград, 1969. 458 дахь тал.

⁹ Martti Räsänen. "Versuch eines etymologischen Wörterbuchs der Türkssprachen" Helsinki, 1969. 282 дахь тал.

гэх мэт хувилбараар түгээмэл тохиолддог "ачаа бараа, тээш тэгнээ" гэсэн утгатай үг¹⁰ байдагтай холбон үзлээ. Тэгэж үзвэл, "гэр ачаа", "гэр бараа" гэсэн хоршоо үг болох бгөөд заахын тийн ялгалын тэг хэлбэрт байгаа хэлзүйн үг болох юм. Түнгүүс-манж төрлийн хэлнүүдэд орон гэр, урц оромж зэргийг заан нэрлэсэн эртний үгийн хэлбэр нь "jüγ" (жууг) болохыг судлаачид тодорхой судалж гаргасныг бас энд холбон үзэж болох мэт. Ямар боловч "МНТ"-ны энэ шүлгийн хэсэгт гарч байгаа "jüg" бол зүг чигийн "зүг" биш юм.

Төгсгөн өгүүлэхэд, "МНТ"-ны судлалыг гүнзгийрүүлэхэд, хожмын монгол сурвалжтай үг үсгээр нь харгуулж, хятад галиг эхийг уйгуржин монгол эхээс буулгасан гэдгийг санан санан эргэцүүлэх нь тус нэмэртэй болохыг тэмдэглэе.

¹⁰ Древне-тюркский словарь, Ленинград, 1969. 285 дахь тал.

